



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/193

Мандалговь

Г Гамшгаас хамгаалах сургууль, үзлэгийг  
зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13.3.2, 32.1.1, 51.4 дэх заалтууд, Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны дүгээр хурлын тэмдэглэл, Аймгийн Засаг даргаас Онцгой байдлын газрын даргатай байгуулсан менежерийн үр дүнгийн гэрээний 1.2,3, 1.2,4 1,2,5 1,2,6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Нэг. Аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг Дэлгэрцогт суманд 2017 оны 06 дугаар сарын 27-29-ны өдрүүдэд,
- Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг Говь-Угтаал суманд 2017 оны 06 дугаар сарын 30-наас 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд,
  - Гамшгаас хамгаалах удирдах бүрэлдэхүүний сургуулийг, Өндөршил суманд 07 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд,
  - Аймгийн Засаг даргын нэрэмжит Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг Хулд суманд 2017 оны 09 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд,
  - Гамшгаас хамгаалах удирдах бүрэлдэхүүний сургуулийг Эрдэнэдалай суманд 2017 оны 09 дүгээр сарын 18-19-ны өдрүүдэд,
  - Гамшгаас хамгаалах удирдах бүрэлдэхүүний сургуулийг Адаацаг суманд 09 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд, тус тус зохион байгуулсугай.

Хоёр. Гамшгаас хамгаалах албадын үзлэгийг “Хүн ам нийгмийн хамгааллын алба”, “Эрүүл мэндийн алба”, “Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж мэдээллэх алба”-дад, 09, 10 дугаар саруудад тус тус явуулж гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангуулж ажиллахыг Онцгой байдлын газар /Онцгой байдлын хурандаа Я.Алтанхундага/-т үүрэг болгосугай.

Гурав. Гамшгаас хамгаалах сургууль, үзлэг зохион байгуулах бүрэлдэхүүнийг 1 дүгээр, шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Дөрөв. Гамшгаас хамгаалах сургууль, үзлэгийг зохион байгуулахад шаардагдах 2,946,750 /хоёр сая есөн зуун дөчин зургаан мянга долоон зуун тавь/-н төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан /Ц.Даваа/-д зөвшөөрсүгэй.

Тав. Гамшгаас хамгаалах сургууль, үзлэгийг батлагдсан бодлого, төлөвлөгөө, удирдамжийн дагуу явуулж дүнг 2017 оны 11 дүгээр сарын 01-ны дотор танилцуулахыг сургуулийн удирдагч /Онцгой байдлын хурандаа Я.Алтанхундага/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

020056!